

**“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН  
2024 ОНЫ 3 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр

Дугаар07

“ГТХЗНТ” УТҮГ

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТҮГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн батлуулсан нэгжүүдийн 3 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үүнээс							Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	
ЗСХ	19	11	-	3	1	-	3	1	75.6
ТНУАСХ	20	16	1	2	-	1	-	-	93.0
ГХБАБМХ	4	4	-	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>	<b>43</b>	<b>31</b>	<b>1</b>	<b>5</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>1</b>	<b>86.2</b>

**Дүгнэлт**

Нэгжүүд 3 дугаар сард төлөвлөсөн 43 ажлын 74.4 хувийг бүрэн хэрэгжүүлсэн, 23.2 хувийг хэрэгжүүлж дуусаагүй байна.

Захиргаа, санхүүгийн хэлтсийн төлөвлөгөөнд тусгагдсан “Захирлын шуурхай зөвлөгөөн зохион байгуулах, тэмдэглэл, үүрэг даалгаврыг хөтлөх, нэгж, ажилтанд шуурхай хүргэх, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж ажиллах”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах”, “Төвийн дотоод үйл ажиллагаанд мөрдөж буй эрхзүйн 5 баримт бичгийг нэгтгэж боловсруулах” гэсэн 3 ажлын хэрэгжилт тасарсан буюу хэрэгжээгүй байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаан тайлант сард 1 удаа хуралдсан бөгөөд ГТХЗНТ-д тусгайлан болон нийтлэг өгсөн үүрэг даалгавар байхгүй байна.

Тайлант сард нийт 18 хариутай бичиг бүртгэгдэж, 13 бичгийг хугацаанд нь, 1 бичгийн хариуг хугацаа хоцроон шийдвэрлэж, ЗТХЯ-наас ирүүлсэн RFID шийдэл танилцуулах тухай,

ТАХ-дыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрт санал ирүүлэх тухай, ...санал ирүүлэх тухай гэсэн 3 албан бичигт хариу өгөөгүй, төвийн хэмжээнд баримт бичиг шийдвэрлэлт 77.8 хувьтай байна.

2024.03.29-ний өдрийн байдлаар шийдвэрлэх хугацаа 10-26 хоног хэтэрсэн 7 албан бичгийн үлдэгдэлтэй байна.

2024.03.29-ний өдрийн байдлаар төвөөс хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, түрээслэгч болон суурь бүтцүүдэд явуулсан нийт 41 бичгийн хариу ирээгүй байна. Үүнд, ГХБАБМХ-ээс явуулсан 16, ТНУАСХ-ээс явуулсан 25 бичигт хариу ирээгүй 5-аас дээш хоногоор саатаж байна.

### **Санал зөвлөмж**

1. Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох зөвлөгөөний протоколын хэрэгжилтийг ирүүлэх тухай албан бичгийг төмөр замуудад хүргүүлж тайлан боловсруулж шаардлагатай арга хэмжээний саналын хамт ЗТХЯ-нд танилцуулах;

2. Шинэчлэн батлагдсан хуулийн хүрээнд галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн удирдлагын төвийн орон тоо, бүтцийг (хүний нөөцийн төлөвлөлт, эрэлт хэрэгцээний судалгаа) бэлтгэх ажилд нэгж, ажилтнууд ямар үүрэгтэй ажиллах ажил үүргийн хуваарилалт хийж эзэн биежүүлэх, Төмөр замын тээврийн тухай хуулийг даган мөрдөх бэлтгэл ажлын нарийвчилсан төлөвлөгөөнд санал тусгах;

3. 2022 онд төслийг нь боловсруулсан Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журмын нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын төмөр замын сүлжээнд галт тэрэгний дугаарлалт хийх заавар, Өртөөний технологийн горим боловсруулах заавар болон зурмаг хөтлөх, боловсруулах зааврын төслийг шинэчлэх;

4. Төвийн энтерфрайз архитектурын загвар боловсруулах судалгаа хийх;

5. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд аялах ачааны галт тэрэгт ST LIS3DH маркийн чичиргээ хэмжих төхөөрөмж суурилуулж туршилт зохион байгуулах;

6. Төмөр замын ачааны захиалгыг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй, шуурхай оновчтой байдлаар зохион байгуулах цахим системийг хөгжүүлэх;

7. ТР ТС 001/2011 Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлын техникийн стандартын төсөлд ЗТХЯ, УБТЗ, МТЗ, ТТЗ, МТЛ, ТЗДС, ТББ-аас санал авах;

8. Архивын баримтын тооллого зохион байгуулж эмхлэн цэгцлэх;

9. Авлига ашиг сонирлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах;

10. ХАБЭА-н харилцааг зохицуулсан журам, зааврыг шинэчлэн батлуулах;

11. Албан хэрэг хөтлөлтийн харилцааг зохицуулсан журам, зааврыг шинэчлэн батлуулах.

### **ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

ТНУАСХ-ИЙН ДАУХГ

**ХЯНАСАН:**

ЗСХ-ИЙН ДАУХГ

**БОЛОВСРУУЛСАН:**

ХШҮМ


А.БУЯННЭМЭХ

Ц.ОЮУНБАТ

Ж.АЛИМАА

С.ЗОЛЗАЯА

Э.ОСОРЖАМАА



Handwritten signatures in blue ink, including a large signature at the top and a signature at the bottom that reads "Э.Осоржамая".